

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭЗЭМШЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

2025.01.22-ны өдөр

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журмын 2.1.4-т заасан чиг үүргийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшил болон эзэмшлийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 12-р сарын 31-ний өдрөөр шинэчлэн гаргаж, олон нийтэд тогтмол мэдээлдэг.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний эзэмшлийг ил тод байдлыг хангах тодорхой зохицуулалтуудыг тусгасан байдаг. Тухайлбал:

- “Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгана.” (19.1 дэх хэсэг);
- “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Зохицуулах хороонд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх тус хуульд заасан мэдээллийг хүргүүлнэ” (19.1 дэх хэсэг);
- “Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх мэдээллийг Зохицуулах хороо олон нийтэд мэдээлнэ”(19.5);
- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг Зохицуулах хороонд гаргаж өгөөгүй, нуусан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авна” (19.6) гэж тус тус заасан байдаг.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн мэдээллийг 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар шинэчлэн гаргаж, олон нийтэд мэдээлж байна.

Хүснэгт 1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн төрөл, тоо (2024.12.31)

Тусгай зөвшөөрлийн төрөл	УБ	Орон нутаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз	18	44
Арилжааны телевиз	52	3
Төлбөртэй телевиз	22	-
Радио	30	36
Олон суваг дамжуулах үйлчилгээ	12	16
Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх	1	-
Монголын үндэсний олон нийтийн радио телевиз	9	-
НИЙТ		243

Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 243 үйлчилгээ эрхлэгчдээс олон нийтийн статустай 9 радио, телевиз болон төрийн өмчит үйлдвэрийн газар, УТҮГ нийт 3 үйлчилгээ эрхлэгч, 20 нь ТББ-ын эзэмшилд байна. Үүнээс 204 тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эзэмшлийн талаарх мэдээллийг маягтын дагуу гарган, Зохицуулах хороонд ирүүлсэн байна.

Зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн мэдээллийг хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын нээлттэй мэдээллийн сан (opendata.mn) -тай тулгаж шалгасны үндсэн дээр эзэмшлийн мэдээллийг эцэслэн гаргадаг.

- 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг авч үзэхэд:

Хүснэгт 2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх зүйн статус

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид нийт тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх зүйн статус									
	НЭЗХЭ (Олон нийтийн)	УТҮГ	ТӨҮГ	ХХК	ТББ	ХМБ*	Нөхөрлөл	ХК	ШБ**	Иргэн
243	9	1	2	204	20	3	1	1	1	1

*Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.2-т “өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно”. гэж заасан байдаг.

Тайлбар: *Хэвлэл мэдээллийн байгууллага, ШБ**- Шашны байгууллага


- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулийн этгээдийн хэлбэрийг авч үзэхэд 83% нь Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэр дээр байна.
- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн шинэчилсэн мэдээллийг 2023 оны эзэмшлийн мэдээлэлтэй харьцуулахад 2024 онд тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээлэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

Хүснэгт 3. Эзэмшлийн өөрчлөлтийн нэгдсэн хүснэгт.

Өөрчлөлтийн төрөл	Тусгай зөвшөөрлийн ангилал	Өөрчлөлтийн тоо (2024)
Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт	УБ. Өргөн нэвтрүүлгийн телевиз (18 ТВ-с)	2
	УБ. Арилжааны телевиз (52 ТВ-с)	8
	Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз (44 ТВ-с)	3
	Радиоогийн үйлчилгээ	УБ Радио-3, Орон нутаг-2
Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд	Улаанбаатар хот. Арилжааны телевиз	7
	Орон нутгийн телевиз	2
	Радио	УБ- 5, Орон нутаг 1
	Олон суваг дамжуулах үйлчилгээ	3


Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй эзэмшигчийн нэгдсэн мэдээллийг Телевиз, радио, олон сувгаар ялгаж харуулбал:

График 1. УБ. Монгол Улсад хамрах хүрээтэй Өргөн нэвтрүүлгийн 18 телевиз.
Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн эзэмшигчдийн бүтэц.




Өргөн нэвтрүүлгийн 18 телевизийн 61% буюу 11 нь 1 эзэмшигчтэй бол 22.4% буюу 2 телевиз 2 эзэмшигчтэй байна.

График 2. Арилжааны телевизүүд. Тусгай зөвшөөрлийн эзэмшигч компанийн эзэмшигчдийн бүтэц.



Арилжааны телевизийн хувьд 1 болон 2 эзэмшигчтэй телевизүүд дийлэх хувийг эзэлж байна. Тодруулбал, 1 эзэмшигчтэй телевиз 29, 2 эзэмшигчтэй телевиз 22 байна.

График 3. Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн эзэмшигчдийн бүтэц



Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизийн хувьд 1 эзэмшигчтэй телевиз 23, 2 телевиз 7 байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.

График 4. Радиогийн үйлчилгээ эрхлэгч - Улаанбаатар хот, орон нутаг

Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн эзэмшигчдийн бүтэц



Радиогийн хувьд мөн 1 эзэмшигчтэй радио дийлэх хувийг бүрдүүлж байна. Тодруулбал, Улаанбаатар хотод 1 эзэмшигчтэй радио 23 байгаа бол орон нутагт 1 эзэмшигчтэй радио 29, 2 эзэмшигчтэй радио 3 байгаа нь нийт эзэмшлийн ихэнх хувийг эзэлж байна. Хуулийн этгээдийн эзэмшлийн бүтцээр авч үзвэл иргэд нийт эзэмшлийн 75 хувийг бүрдүүлж байгаа нь ажиглагдлаа.




График 5. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч - Улаанбаатар хот, Орон нутаг



Улаанбаатар хотын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн 7 нь 1 эзэмшигчтэй бол 3 нь 2 эзэмшигчтэй байна. Харин орон нутгийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нийт 16 байгаагаас 13 нь 1 эзэмшигчтэй байна.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=304> холбоосоор орж танилцана уу.